



WORLD GROWTH
MONGOLIA



Дэлхийн Өсөлт
Монголын Төсөл

МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ТОГТОЛЦОО БА УУЛ УУРХАЙН САЛБАР

Дэлхийн Өсөлт олон улсын
байгууллагын судалгаа

2008 оны 12 дугаар сар

Агуулга

1. Хураангуй	3	Хавсралт А: Папуа Шинэ Гвиней	
2. Оршил	5	улсын татварын орчин ба уул	
3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн		уурхайн хөгжил	17
албан татварын хуультай холбоотой			
ноцтой асуудлууд	7	Хавсралт Б: Чили улсын татварын орчин	
4. Нөөцийн түрээсийн татвар		ба уул уурхайн хөгжил	19
оновчтой шийдэл биш	11	Хавсралт В: Монгол улсын уул уурхайн	
5. Үлдэж буй цорын ганц сонголт	13	татварын тогтолцоог олон улсын шилдэг	
		жишигт ойртуулах талаар Дэлхийн	
		Банкнаас өгсөн зөвлөмж	23

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтөд албан татвар (ЗБҮӨАТ) ногдуулах, мөн “стратегийн ач холбогдолтой” орд газруудад Төр багагүй хувь эзэмших асуудлыг хуульчилснаар Монгол улсын уул уурхайн салбар дахь өмчийн эрхийн оновчтой тогтолцоог сулруулсан юм. Бодлогын хүрээнд алдаатай зүйлс байгаа нь олон улсын уул уурхайн компаниудын болон хөндлөнгийн бие даасан шинжээчдийн хийсэн судалгаагаар нотлогдож байна.

Монгол улсын геологийн чамгүй нөөц боломжийг ашиглахын тулд ихээхэн хэмжээний хөрөнгө, мэдлэг туршлага шаардлагатай боловч Монголд ийм чадамж бүрдээгүй байна. Уул уурхайн салбарт татварын болон зохицуулалтын хэр оновчтой тогтолцоог бүрдүүлэхээс байгалийн тэрхүү нөөцөө Монгол улс иргэн бүртээ үр өгөөжтэйгээр ашиглаж чадах эсэх нь шалтгаална.

Гэнэт цоо шинээр санаачлан нэвтрүүлсэн ЗБҮӨАТ нь татварын бодит хувь хэмжээг (ТБХХ) дэлхийд хамгийн оновчтой тогтолцоотой хэмээгддэг Чили, Ботсвана зэрэг улсынхаас даруй хоёр дахин их болгожээ. Түүнчлэн, эдгээр орны хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад үзүүлдэг институциональ хамгаалалт нь Монголынхоос хавьгүй илүүд тооцогддог билээ.

Монгол улсын уул уурхайн салбар дахь татварын бодит хувь хэмжээг хэт нэмэгдүүлснээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг уул уурхайн салбараас дайжихад хүргээд байна. Татварын тогтолцоон дахь сүүлийн үеийн өөрчлөлтүүд нь Монгол улсын хөрөнгө оруулалтын эрсдлийг нэмэгдүүлнэ гэсэн төсөөллийг хөрөнгө оруулагчдын дунд бий болгожээ. Дээрх хоёр хүчин зүйлс нь Монгол улсын төсвийн орлого, хөдөлмөр эрхлэлт, ДНБ-нд бодитой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Гэнэтийн ашгийн татвараас үүдэлтэй эдийн засгийн бэрхшээлийн улмаас зарим хүмүүс энэ татварыг халж оронд нь “нөөцийн түрээсийн татвар” (Resource Rent Tax or RRT)-ыг бий болгохыг санал болгож байна. Нөөцийн түрээсийн татвар нь ЗБҮӨАТ-ын илүү боловсронгуй хувилбар боловч түүний эдийн засгийн гол сул талуудыг агуулсан хэвээр байх тул энэ нь бодит утгаараа төдийлөн зохистой бодлогын шийдэл болж чадахгүй.

Уул уурхайн салбарын татварын дэглэмийг боловсруулахад анхаарах чухал асуудлын нэг нь татварын хувь хэмжээ болон татварын суурь баазын хоорондын хамгийн оновчтой тэнцвэрийг олоход оршино. Татварын хувь хэмжээ, татварын суурь баазын аль аль нь чухал ач холбогдолтой. Тэдгээрийн

арифметик үржвэр нь цуглуулж хураасан татварын орлогын дүнг тодорхойлох боловч татварын түвшин нь татварын суурь баазын цар хэмжээнд маш том нөлөө үзүүлдэг. Татварын хувь хэмжээг зарим тодорхой түвшнээс дээш өсгөж нэмэгдүүлэх нь татвар төлөхөөс зайлсхийх явдлыг даамжруулж улмаар ашиг орлого огт бүрдүүлэхгүй байдалд ч хүрдэг. Энэ байдал алт олборлолтод гэнэтийн ашгийн татвар ногдуулснаар огт хүсээгүй үр дагаварт хүргэж байгаагаар илэрсэн билээ.

Уул уурхайн татварыг оновчтой тогтоох нь ашигт малтмалыг ашиглах эдийн засгийн үр өгөөжийг урт хугацаанд боломжийн хэрээр өсгөн нэмэгдүүлдэг ч дэлхийн шилдэг тэргүүн туршлагыг бий болгоход энэ нь дангаараа хангалттай биш гэдгийг Чилийн жишээ тодорхой харуулдаг. Бодлогын ерөнхий орчин хүрээ нь тогтвортой, цаашдын төлөв нь урдаас тодорхой байх явдал зайлшгүй чухал. Чили улсын жишээ нь зохицуулалтын орчинг оновчтой бүрдүүлсний үр өгөөжийг харуулахын хажуугаар энэхүү орчинд өөрчлөлт хийх нь олон улсын түвшинд өрсөлдөх чадварын асуудлаар ихээхэн чармайн байж олж авсан байр сууриа хэрхэн амархан алдаж болохыг мөн харуулдаг.

Томоохон шинэчлэл хийх бодлогын чиг баримжаа Монгол улсад байгаа нь тодорхой байна. Дотоодын хөдөлмөр эрхлэлт, ДНБ болон татварын орлогыг урт хугацаанд тогтвортой нэмэгдүүлж, улмаар ард иргэдийн аж амьдралд бодитой хувь нэмэр оруулж чадахуйц уул уурхайн салбарыг хөгжүүлэх үүднээс татварын бодит хувь хэмжээг дорвитой бууруулах нь зүйтэй.

Гэнэт цоо шинээр санаачлан нэвтрүүлсэн

ЗБҮӨАТ нь татварын бодит хувь хэмжээг

(ТБХХ) дэлхийд хамгийн оновчтой тогтолцоотой

хэмээгддэг Чили, Ботсвана зэрэг улсынхаас

даруй хоёр дахин их болгожээ.

Оршил

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдуулан уул уурхайн салбар дахь харилцааг зохицуулах үүднээс *Ашигт малтмалын тухай хуулийг* Монгол Улсын Их Хурал 1997 онд баталсан. Тус хуулийн гол ололт нь ашигт малтмалын хайгуул, олборлолт ба боловсруулалтын салбарт ил тод, найдвартай, арилжих боломжтой өмчийн эрхийн тогтолцоог бүрдүүлсэн явдал бөгөөд үүгээр ашигт малтмалын салбар үсрэнгүй хөгжих үндэс суурийг тавьж өгсөн.

2006 онд Улсын Их Хурлаас 1997 оны хуульд нэмэлт өөрчлөлт оруулахын сацуу нэгэн шинэ татвар тогтоосон. Хууль эрх зүйн хүрээн дэх томоохон өөрчлөлтүүдийг онцолбол:

- Алт, зэсэнд 68%-ийн гэнэтийн ашгийн татвар /ЗБҮӨАТ/ ногдуулах
- Стратегийн ач холбогдолтой бүх орд газрын 50 хүртэлх хувийг Монголын төр эзэмших тухай заалт зэрэг болно.

Эдгээр өөрчлөлтүүд нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад нэн тааламжгүй нөхцлийг бүрдүүлж байгаагаараа Монгол улсын уул уурхайн салбарт томоохон ухралт болсон. Монгол улсын гол институциудын сул дорой байдал, мөн дэлхийн санхүүгийн хямрал, дэлхийн зах зээл дээрх металлын үнийн огцом уналт, дотоодын цалин хөлсний огцом өсөлт, Ашигт малтмалын тухайн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай удаа дараагийн саналууд зэрэг сүүлийн үеийн үйл явдлын өрнөл дээрх өөрчлөлтүүдийн сөрөг нөлөөллийг улам даамжруулж байна.

Дэлхийн санхүүгийн хямрал нь Монголын төдийгүй бусад улс орны уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтад ноцтой нөлөөлж буй нь илт байна. Эрсдэл хийсний төлөө хүртэх ашиг өгөөжийн хувь өндөрсөнө хэмээх хүлээлт хөрөнгө оруулагчдын дунд нэмэгдэж байгаагийн зэрэгцээ урт хугацааны бизнесийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зээлийн нөхцлүүд чангарсан нь хөрөнгө босгох өртгийг хаа сайгүй өсгөж байна.

Уул уурхайн бизнес нь их хэмжээний капитал

хөрөнгө оруулалт шаардаж, ашигт малтмалын ордыг олон жилийн турш ашигладаг онцлогтой тул уул уурхайн салбар нь дээр дурьдсан хүчин зүйлийн нөлөөлөлд туйлын мэдрэг юм. Уул уурхайн салбарын бодлогоос хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын чанар ихээхэн шалтгаалдаг

Үүнээс үүдэн дэлхийн хэмжээний уул уурхайн томоохон компаниуд шинэ газар эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийхийн оронд одоо ашиглаж буй уурхайнуудаа өргөтгөхийг илүүд үзэж байна. Тухайлбал, Рио Тинто компани төлөвлөж буй хөрөнгө оруулалтын төслүүдийнхээ үнэлгээг эргэн харж Оюу Толгойд хийх хөрөнгө оруулалтын саналаа түдгэлзүүлж болзошгүй байна.¹

Канадын Фрэйзерийн Хүрээлэнгээс дэлхийн уул уурхайн томоохон компаниудын удирдах ажилтнуудын хүрээнд явуулсан саяхны судалгаанд Монгол улсын бодлогын хүрээн дэх алдаа дутагдлуудыг онцлон дурдсан байна. 2007-2008 онд 68 орныг харьцуулан судлахад Монгол улс доороосоо 8-д бичигджээ. Цаашилбал, 2006 онд *Ашигт малтмалын тухай хуульд* нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө хийгдсэн 2005-2006 оны судалгаатай харьцуулбал Монгол улс 28 байраар ухарчээ. Фрэйзерийн Хүрээлэнгийн судалгаанд дурдагдсан алдаа дутагдлууд дараа дараагийн хөндлөнгийн шинжээчдийн судалгаанд мөн тэмдэглэгдсэн байна.²

Эдгээр өөрчлөлтүүд нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад нэн тааламжгүй нөхцлийг бүрдүүлж байгаагаараа Монгол улсын уул уурхайн салбарт томоохон ухралт болсон.

Монгол улс геологийн асар их потенциалтай. Энэхүү нөөц боломжийг ард иргэддээ өгөөжтэй ашиглахад ихээхэн хэмжээний санхүүгийн хөрөнгө, нарийн мэргэжлийн мэдлэг туршлага Монгол улсад шаардагдана. Эдгээр нь Монгол улсад хараахан бүрдээгүй тул энэхүү нөөцийг гаднаас л авах боломжтой. Монгол улсын уул уурхайн салбарт

1 Rebecca Bream, 2008, 'Brutal reversal stuns mining groups', *The Financial Times*, 30 October, accessed at <http://www.ft.com/cms/s/0/f03b2344-a6b9-11dd-95be-000077b07658.html> /Ребекка Брим, "Уул уурхайн группуудыг цочирдуулсан уналт"/

2 James Otto, 2007, 'Competitive Position of Mongolia's Mineral Sector Fiscal System: the Case of a Model Copper Mine', *mimeo*, January, accessed at <http://21576430.domainhost.com/docs/Dr.%20James%20Otto%20-%20Mongolia%20Competitive%20Tax%20Report%20%202007.pdf> and International Monetary Fund [IMF], 2008, *Mongolia: Selected Issues and Statistical Appendix*, IMF Country Report No. 08/201, IMF, Washington, DC, July, accessed at <http://www.imf.org/external/pubs/ft/scr/2008/cr08201.pdf> /Жэймс Оттоо "Монголын уул уурхайн салбарын татварын тогтолцооны өрсөлдөх чадвар: Зэсийн загвар уурхайн жишээ", ОУВС "Монгол улс: Онцлох асуудлууд, статистик үзүүлэлтүүд", ОУВС тайлан

үйлчилж буй татвар, зохицуулалтын хүрээ нь энэхүү салбараас хүртэх үр өгөөжийг тодорхойлогч гол хүчин зүйл юм.

Энэхүү судалгаанд Монгол улсын уул уурхайн салбарын татварын өнөөгийн тогтолцоон дахь хүндрэлтэй асуудлуудыг, ялангуяа ЗБУӨАТ-ыг

өөрчлөх нь дээрх бэршээлүүдийг шийдвэрлэж чадах эсэхийг авч үзлээ. Ингэхдээ уул уурхайн бизнесийг хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц хэмжээнд хөгжүүлэхийн тулд татварын орчноо хэрхэн яаж өөрчлөх, энэ нь Монголын нийт иргэдэд урт удаан хугацаанд ямар үр өгөөж авчрахыг тус судалгаанд анхааран судалсан болно.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хуультай холбоотой ноцтой асуудлууд

1997 оны Ашигт малтмалын тухай хуулиар Монголын уул уурхайн салбарын татварын хүрээ нь нөөц ашигласны татвар /роялти/, мөн эдийн засгийн үйл ажиллагаанд ногдуулдаг нийтлэг татваруудыг багтаадаг байв. Нийтлэг татвар гэдэгт Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмүү өртгийн албан татвар, импортын албан татвар, нефть шатахууны онцгой албан татвар хамаарна. Тухайн үед Монгол улсын уул уурхайн салбарын ашигт ногдуулсан татварын бодит хувь хэмжээ нь /ТБХХ/ одоогийнхоос хамаагүй бага боловч олон улсын түвшинтэй жишвэл харьцангуй өндөр байжээ.³ 2004 онд Дэлхийн Банкнаас тооцоолсноор уул уурхайн салбарт ногдуулах ТБХХ нь Чилид 17% байсан бол Монголд 33% байв.⁴


2006 онд УИХ-аас баталсан ЗБҮӨАТ-ын тухай хуулиар нэг тонн зэсийн суурь үнийг 2600 ам доллар,

нэг унц алтны босго үнийг 500 ам.доллараар тооцож, түүнээс дээш гарсан борлуулалтын орлогод гэнэтийн ашгийн татвар ногдуулахаар заажээ. 2008 оны дундуур дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын үнэ уналтанд орсны дараагаар уг хуулин дахь нэг унц алтны босго үнийг 850 ам.доллар болгон өсгөхөөр болж харин зэсийн босго үнийг өөрчлөхгүй юм байна. Зэсийн хувьд татвар төлөгч нь татвар ногдуулах орлогыг тооцохдоо Лондонгийн металын бирж дээрх зэсийн үнээс хүдэр олборлох болон баяжмал үйлдвэрлэх үйл ажиллагааны зардал дээр ашгийг 100 хувиар тооцож нэмсэн дүнг хасуулах боломжтой.

Тухайн үед ЗБҮӨАТ-ын тухай хууль өөрөө, мөн тус татварыг маш өндөр хувь хэмжээгээр тогтоосон (68%) явдал нь урьд өмнө гарч байгаагүй санаа байв. Энэ хуулийн үр дүнд Оюу Толгой шиг зэсийн томоохон уурхайн хувьд ТБХХ нь даруй 80% гаруй хувь болж нэмэгдэхийг ОУВС тооцоолжээ.⁵ Энэ нь дэлхийн шилдэг уул уурхайн татварын хууль тогтоомжтойд

Зураг 1

Алт, зэсийн томоохон уурхайгаас төсөвт орох татварын нийт орлого, зарим орны хууль тогтоомжоор



Эх сурвалж: Дэлхийн Өсөлт байгууллагын тооцоо


3 Татварын бодит хувь хэмжээ /ТБХХ/ нь эдийн засгийн үйл ажиллагаанд ногдуулж буй нийт татварын харьцангуй ачааллын хэмжүүр юм. Энэ утгаараа ТБХХ нь улсын төсөвт төлж буй татвар, хураамж, төлбөрийн нийлбэр бөгөөд уул уурхайн тухайн хөрөнгө оруулалтын хоригдуулсан бэлэн мөнгөний урсгалын тодорхой хувиар илэрхийлэгдэнэ.

4 The World Bank, 2004, *Mongolian Mining Sector: Managing the Future*, The World Bank, Washington, DC /Дэлхийн банк “Монголын уул уурхайн салбар: Ирээдүйг Удирдахуй”/

5 IMF 2008 /ОУВС/

Зураг 2

Алт, зэсийн томоохон уурхайн татварын дараахь нийт ашиг, зарим орны хууль тогтоомжоор



Эх сурвалж: Дэлхийн Өсөлт байгууллагын тооцоо

тооцогддог Чили, Ботсвана зэрэг орны ТБХХ-нээс даруй хоёр дахин өндөр юм.

Чили, Папуа Шинэ Гвиней, Монгол зэрэг орны уул уурхайн өнөөгийн татварын хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх татварын нийт орлогыг Зураг 1-д харьцуулж үзүүлэв. Тус харьцуулалтыг хийхдээ Оюу Толгойн үйлдвэрлэлийн хүчин чадалд дүйцэхүйц хэмжээний алт, зэсийн уурхайн санхүүгийн загварт тулгуурлав.⁶ Тухайн ордыг 30 жил ашиглахаар төсөөлж алт, зэсийн бодит үнийг 1978-2007 оны хооронд дэлхийн зах зээл дээр байсан үнийн түвшинг жишиг болгон орлогыг тооцоолов. Уурхайд хөрөнгө оруулсан хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчийн хүргэх татварын дараах нийт ашгийг Зураг 2-т харуулав. Үүнийг Зураг 1-д ашигласан үндэслэлээр тооцож бэлтгэсэн болно.

Зураг 3-т Монгол дахь зэсийн томоохон уурхайгаас олох нэгж долларын орлого нь Засгийн газар, уурхайн хөрөнгө оруулагчид, тэдний бэлтгэн нийлүүлэгчдийн дунд хэрхэн хуваарилагдахыг үзүүлэв. Энэ тооцоог 2007 оны алт, зэсийн дундаж үнэд тулгуурлаж хийсэн бөгөөд үүнд Монгол улсад одоо үйлчилж буй татвар

болон зохицуулалтын хүрээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад нэгж долларын орлогын хэр өчүүхэн хэсэг ногдохыг харуулав. Нөгөө талаас Засгийн газар татвараар дамжуулан нэгж долларын орлогоос 45 центийг авахаар харагдаж байна.


Олон улсын Транспаренси Интернэйшнл байгууллагын Авилгын төсөөллийн индекс, мөн Фрэйзерийн Хүрээлэнгээс жил бүр уул уурхайн компаниудын дунд явуулдаг судалгаагаар хувийн хөрөнгө оруулагчдын үзэж байгаагаар Чили, Ботсван зэрэг орны институциуд нь Монголынхтай харьцуулбал хавьгүй чадамжтайд тооцогддог. Эдгээр институциональ сул талууд дараахь байдлаар илэрч байна. Үүнд:

- “Стратегийн ач холбогдолтой” гэгдэх ашигт малтмалын ордуудад төр ахиу хувь эзэмших санаархал,
- 2006 оноос хойш уул уурхайн татварын болон зохицуулалтын орчинд хийсэн өөрчлөлтүүд ба цаашид өөрчлөх сонирхол,
- Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд ил тод байдал дутмаг,

6 See Ivanhoe Mines Ltd, 2008, *Oyu Tolgoi Gold and Copper Project, Southern Mongolia*, accessed at www.ivanhoe-mines.com/s/OyuTolgoi.asp /Айвенхоу Майнз ХХК, “Оюу Толгойн алт, зэсийн төсөл, Монгол улсын өмнөд бүс” вебсайт үзнэ үү/

Зураг 3

Монгол улсын томоохон зэсийн уурхайгаас олох нэгж ам.доллар орлогын хуваарилалт



Эх сурвалж: Дэлхийн Өсөлт байгууллагын тооцоо

- Өмчийн эрхийн тодорхойлолт сул, хамгаалалт найдваргүй,
- Шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаа асуудалтай,
- Улс төрийн авилга.

Олон улсын түвшинд уул уурхайн хууль, тогтоомжийн зохицуулалтаар өрсөлдөхүйц болохын тулд Монгол улс хувийн хөрөнгө оруулагчдад тавигдах шаардлагыг зөөлрүүлэх шаардлагатайг дээрх институциональ сул талууд илтгэн харуулж байна. Монголын Засгийн газар уул уурхайн салбар дахь ТБХХ-г өнөөгийн өндөр хувь хэмжээг хэвээр хадгалбал ашигт малтмалын хайгуул, ашиглалтыг сүйрэлд оруулж болзошгүй.

ЗБҮӨАТ нь татвараас зайлсхийх явдлыг амьдрал дээр аль хэдийн даамжруулжээ.⁷ ЗБҮӨАТ-ын тухай хууль баталснаас хойш дэлхийн зах зээл дээрх алтны үнэ эрс нэмэгдсэн хэдий ч албан ёсны мэдээгээр алтны үйлдвэрлэл үлэмж буурч, алт хууль бусаар хил гаргах явдал гaarчээ. Дараагийн ээлжинд геологийн хайгуулын ажил энэ хуулийн золиос болох нь ээ. Ашиглалтын өмнөх шаганд үйлдвэрлэлд бэлтгэгдэж байгаа уул уурхайн олон төсөл ашигтай хэрэгжих нь эргэлзээтэй болж байна. Цаг хугацаа өнгөрөх тусам хувийн хөрөнгө оруулагчдын зүгээс шинэ төсөл хэрэгжүүлэх явдал улам цөөрнө.

Монгол улсын хууль тогтоогчид эдгээр эрсдлийн заримыг хүлээн зөвшөөрч анхаарах болж байна. Ашигт малтмалын хуулиар Монгол улсын Засгийн газар ашигт малтмалын лиценз эзэмшигчтэй орд газрыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрхтэй болсон.

Хөрөнгө оруулалтын гэрээгээр лиценз эзэмшигч нь татварын зарим хөнгөлөлт эдлэх бөгөөд үүнд ЗБҮӨАТ-аас 30 хүртэл жилээр чөлөөлөх тухай заалт багтаж байна.


Засгийн газар Оюу Толгойн ордыг ашиглахад яг энэ зарчмаар ажиллахыг санал болгоод байна. Энэ мэт зарим саналын эрх зүйн чадамжийн тухай асуудал эргэлзээ төрүүлэхийн зэрэгцээ ийм гэрээ нь Монгол улсад хөрөнгө оруулалт хийх эрсдлийг бууруулахын оронд харин ч нэмэгдүүлж болзошгүй талаар болгоомжлол бий болж байна.

Монгол улсын уул уурхайн салбарт үйлчилж буй татварын тогтолцоо нь тус салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын түвшинг бууруулж улмаар Монголын эдийн засагт янз бүрийн хэлбэрээр илрэх сөрөг нөлөөг үзүүлэх болно. Хамгийн наад захын үр дагавар нь уул уурхайн салбар дахь хөдөлмөр эрхлэлт буурч, тус салбараас ДНБ-д оруулах хувь нэмэр багасахад хүрнэ. Тодорхой хугацааны дараа уурхайнуудын тоо, үйлдвэрлэлийн хүчин чадлаар хэмжигдэх татварын

⁷ Монгол улсын Засгийн газар “Хууль улсын хууль: Ашигт малтмалын хуульд оруулах нэмэлт өөрчөлт оруулах тухай”, УИХ-ын Даргад өргөн барьсан хуулийн төсөл, Улаанбаатар, 5 сарын 14

Зураг 4

2008 оны үзүүлэлтээр, алт, зэсийн үнийн индексийг алт, зэсийн ЗБҮӨАТ-ын босго үнийн жигнэсэн дундажтай харьцуулах нь



Эх сурвалж: Дэлхийн Өсөлт байгууллагын тооцоо

суурь бааз хумигдах талтай. Одоо ашиглагдаж буй уурхайн нөөц дуусч, тэдгээрийг орлох шинэ уурхай ашиглалтанд орохгүй тохиолдолд төсвийн орлого тасралтгүй буурсаар байх болно.

2008 оны дунд үеэс дэлхийн зах зээл дээр металлын үнэ буурснаас үүдэн УИХ гэнэтийн ашгийн татвар ногдуулах үнийн босго түвшинд тохиргоо хийхээр болоод байна. Ингэхдээ нэг унц алтанд ногдуулах татварын босго үүнийг 500 ам.доллар байсныг 850 ам.доллар болгож нэмэгдүүлэхээр тохирчээ.

Гэнэтийн ашгийн татвар ногдуулах одоогийн босго үнийн жигнэсэн дундаж хэмжээг 1978–2007 оны турш дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн жилийн бодит үнийн индексгүй харьцуулсныг Зураг 4-т харуулав.⁸ Өнгөрсөн 30 жилийн ихэнх хугацаанд эдгээр хоёр металлын жилийн дундаж үнэ нь гэнэтийн ашгийн татварын композит босгоос өндөр төдийгүй тус босго хэмжээнээс наанадаж зургаан тохиолдолд хавьгүй өндөр /гуравны нэг буюу түүнээс илүү/ байсан нь графикаас харагдаж

байна. Үнэхээр 2007 оны оргил үнэ нь урьдын оргил үнийн түвшнээс хамаагүй өндөр байжээ.

Энэ хүснэгтэд үзүүлээгүй боловч алт, зэсийн үнэ 2008 оны дунд үеэс эхлэн эрс буурсан билээ. 2008 оны 12 дугаар сарын 11-ний байдлаар Лондонгийн металлын бирж дээрх зэсийн үнэ ЗБҮӨАТ-ын босго үнээс хавьгүй илүү байж фьючерсийн гэрээнүүд дэх төсөөлөл өсөх төлөвтэй байна.⁹ Харин алтны үнэ буурч 2008 оны 12 дугаар сарын 12-ны байдлаар Лондонгийн алтны зах дээр (London Bullion Market) хуулийн хэлэлцэгдэж буй босго үнээс үл ялиг бага болсон байв.¹⁰

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд гэнэтийн ашгийн татвар ямар ойрхон давтамжтайгаар үйлчлэх байсан нь дээрх зургаас харагдаж байгаа биз ээ. Огтлолцлын дундах зайгаар энэхүү татварыг ногдуулах болгонд татварын ачаалал хэр нэмэгдэх байсныг харуулжээ. ЗБҮӨАТ нь Монголын хөрөнгө оруулалтын орчинд ноцтой сөрөг нөлөөлөл үзүүлэх байсныг дээрх зургууд харуулж байна.

8 Үнийн индексийг тооцохдоо алт болон зэсийн бүрэлдэхүүн хэсгийг Оюу Толгой төслийн алт, зэсийн үйлдвэрлэлийн хувиар жигнэжээ. Металлын үнийг 2008 оныхоор тооцож АНУ-ын ДНБ-ний таамаглаж буй дефлятороор индексжүүллээ. Мөн энэ аргачлалаар ЗБҮӨАТ-ын үнийн босгын жигнэсэн дундажийг тооцсон болно.

9 London Metals Exchange, 2008, *Copper Grade A*, accessed at <http://www.lme.co.uk/copper.asp> on 13 December. //Лондонгийн металлын бирж, 2008, *Зэсийн А Агуулга*/

10 London Bullion Market Association, 2008, *Prices of Friday 12 December 2008*, accessed at <http://www.lbma.org.uk/index.php> on 13 December //Лондонгийн алтны захын ассоциаци, 2008, 2008 оны 12 дугаар сарын 12-ны Баасан гарагийн үнэ/

Нөөцийн түрээсийн татвар оновчтой шийдэл биш

Монгол улсын уул уурхайн татварын тогтолцоотой холбоотой, ялангуяа ЗБҮӨАТ-ыг нэвтрүүлснээс үүдсэн эдийн засгийн төвөгтэй асуудлуудаас улбаалан зарим хүмүүс гэнэтийн ашгийн татварыг халж оронд нь хөрөнгө оруулалтад арай бага сөрөг нөлөө үзүүлэхүйц татварын хэлбэр хэрэглэхийг санал болгож байна. Санал болгож буй зохистой гэж үзсэн хувилбар нь “нөөцийн түрээсийн татвар” (Resource Rent Tax or RRT) юм. “Нөөцийн түрээсийн татвар” (НТТ) нь гэнэтийн ашгийн татварын илүү боловсронгуй хувилбар хэдий ч эдийн засгийн талаас авч үзвэл гол сул талуудын ихэнхийг агуулсан байдаг байна.

Жинхэнэ утгаараа НТТ нь уул уурхайн төслийн хорогдуулсан цэвэр бэлэн мөнгөний урсгалд (discounted cash flow) ногдуулах татвар юм. Хөрөнгө оруулагчдад очих өгөөжийн дотоод хувь хэмжээ (internal rate of return) нэрлэсэн босго түвшнээс хэтэрсэн нөхцөлд тус татварыг ногдуулна. Онолын хувьд, босго өгөөжийн дотоод хувь хэмжээг ижил төстэй уул уурхайн төслийн эрсдлийг нь тооцож шингээсэн өгөөжийн дотоод хувь хэмжээг “ердийн/боломжийн” өгөөжийн дотоод хувь хэмжээ гэж үзэн сонгоно. Босгыг төслийн хайгуул, барилга байгууламж, үйл ажиллагааны аль ч үед тохиох бүхий л зардлыг хассаны дараа тооцож тогтооно. Үүнд Засгийн газраас ногдуулах бүхий л татвар, төлбөр, хураамжууд багтана.

Ийм үндэслэлээр ногдуулах нөхцөлд НТТ нь тухайн төслийн бүрдүүлсэн “эдийн засгийн ашиг”-г л энэ татварт хамруулах ёстой. “Эдийн засгийн ашиг” гэдэг нь эрсдлийг тооцсоны дараах, хөрөнгө оруулагч өөрөө хүлээн зөвшөөрч төслийг сайн дураараа хэрэгжүүлэх сонирхол төрүүлэхүйц хэмжээний ашгийн хамгийн бага болон түүнээс дээш түвшинг хэлнэ. Энэ зарчмаар ногдуулсан нөхцөлд НТТ-ийг тухайн уул уурхайн төсөлд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацааны талаарх аливаа шийдвэрт нөлөөлөхгүй гэж үздэг. Онолын талаас сонирхол татахуйц боловч энэ татварыг эдүгээг хүртэл ердөө хоёрхон оронд хэрэгжүүлжээ.

Папуа Шинэ Гвинейд НТТ-ын үзэл санааг уул уурхай, нефтийн салбарт нэвтрүүлсэн. 1970-аад онд нэвтрүүлж эхэлснээс хойш тус татварт олон янзаар өөрчилж түүний олон хувилбарыг нэгэн зэрэг ногдуулж байв. Хамгийн сүүлд энэ татварыг Нэмэгдсэн ашгийн албан татвар хэмээн Аж ахуйн нэгжийн татвар дээр нэмж ногдуулах болсноор компанийн орлогод ногдох

татварын хэмжээ 35%-иас 58% орчим болж нэмэгдсэн.

Австралид Холбооны Засгийн газар НТТ-ын үзэл санааг далайн гүнээс олборлох нефть, хийн төслүүдэд нэвтрүүлжээ. Энэ нь компанийн орлогод ногдох татварын хэмжээг 30-аас 60% хүртэл нэмэгдүүлсэн. Муж улсын түвшинд Өмнөд Австралийн засаг захиргаа энэ зарчмыг томд тооцогддог Roxby Downs уурхайд нэвтрүүлсэн.

Бодит амьдралд цэвэр “НТТ” гэж бараг байхгүй. Үндсэн зарчим, үзэл санааны хувьд энэ нь компанийн татвар, нөөц ашигласны татварыг хослуулсан хэлбэр юм. Энэ татварын энэхүү хоёрдмол шинж чанар нь хөрөнгө оруулалтыг зөвхөн л сарниулах магадлалыг нэмэгдүүлдэг.

Эдүгээг хүртэлх Папуа Шинэ Гвинейн НТТ-тай холбоотой туршлага нь зөвтгөхийн аргагүй алдаа байсан тухай Хавсралт А-д дэлгэрэнгүй тусгав. НТТ-ыг нэвтрүүлснээс дэлхийн хайгуулын хөрөнгө оруулалтад тус орны эзлэх хувь хэмжээ эрс буурч, тус улсын Засгийн газар НТТ-ыг 2003 онд халах хүртэл байдал сайжраагүй ажээ. Түүнчлэн Папуа Шинэ Гвинейгээс экспортлох ашигт малтмалын хэмжээ хэсэг хугацааны турш буурах хандлагатай болсон. Энэ нь тогтоогдсон нөөц шавхагдах, мөн саяхныг хүртэл хайгуулын ажилд хөрөнгө оруулалт бараг хийгдэж байгаагүйг илтгэнэ.¹¹ Гэвч ExxonMobil-ын хэрэгжүүлэх гэж буй Папуа Шинэ Гвинейн “PNG LNG” төсөлд НТТ-ыг сэргээн нэвтрүүлснээр тус орны эрдэс баялгийг нээж ашиглах салбарын хөрөнгө оруулалт болон үндсэн эрсдлийн талаарх хувийн хөрөнгө оруулагчдын санаа бодол, үнэлгээнд сөргөөр нөлөөлөх эсэхийг харах л үлдэж байна.

Папуа Шинэ Гвинейд ашиглаж буй НТТ-ын үндсэн зарчмуудыг Монгол улсын ЗБҮӨАТ-ыг халж орлуулах нөхцөлд (i) төсөвт оруулах орлогын хэмжээ

НТТ-ыг нэвтрүүлснээс дэлхийн хайгуулын хөрөнгө оруулалтад тус орны эзлэх хувь хэмжээ эрс буурч, тус улсын Засгийн газар НТТ-ыг 2003 онд халах хүртэл байдал сайжраагүй ажээ.

11 IMF [International Monetary Fund], 2008, *Papua New Guinea: Selected Issues and Statistical Appendix*, IMF Country Report No. 08/93, International Monetary Fund, Washington, DC, March, accessed at www.imf.org/external/pubs/ft/scr/2008/cr0893.pdf in 9 December 2008 /OYBC, Папуа Шинэ Гвиней: Онцлох асуудлууд, статистик үзүүлэлтүүд/

(Зураг 1-ээс үзэх), (ii) хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдын хүртэх татварын дараах ашгийн (Зураг 2-т үзэх) аль алинд тун бага нөлөөлөхөөр байгааг бидний хийсэн тооцоо харуулав. Энэ нь уг татварыг ногдуулснаар уул уурхайн татварын одоогийн тогтолцооны үндсэн дутагдлыг шийдэхгүй. Тухайлбал, дэлхийн шилдэг уул уурхайн хууль тогтоомж бүхий орнуудтай харьцуулахад татварын ачаалал өндөр хэвээр байхаар байна. Өөрөөр хэлбэл Монголын хөгжилд амин чухал ач холбогдолтой Монголын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт татах боломж нөхцөл муу хэвээр байх болно.

Татварын нийт ачааллын түвшинг нэмэгдүүлэхийн сацуу ашигт ногдуулах энэхүү татвар нь хүмүүсийн бизнес эрхлэх сонирхолд нөлөөлөхгүй гэх аргагүй.

Эдийн засгийн ашиг нь туйлын тодорхой бус орчинд бизнесийн авхаалж овсгоо гаргасны төлөөх шан гэж ойлгож болно. Ийм орчинд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг зөв зүйтэй илрүүлж тодорхойлохын зэрэгцээ тэрхүү хэрэгцээ шаардлагыг хангах хөрөнгө, ажиллах хүчийг олж зохион байгуулах шаардлагатай болдог. “Ердийн” гэгдэх ашиг нь зөвхөн хөрөнгө гаргаж байгаа талуудын зардлыг нөхөхөд л хүрэлцээтэй. Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлэн бүтээгдэхүүний шинэ зах зээл нээх, эсвэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинэ аргуудыг бий болгоход “ердийн” гэгдэх энэ ашгийн түвшин хангалтгүй.

НТТ-ын аргаар ашигт малтмалын ашиглалтаас олсон эдийн засгийн ашигт татвар ногдуулах нь ашигт малтмалын хайгуул, нэгэнт илрүүлж тогтоосон орд газруудыг ашиглах санхүүжилтыг бүрдүүлэх хөрөнгө оруулагчдын бизнес сэдлийг бууруулж хүсэл эрмэлзэлд нь сөрөг нөлөө үзүүлнэ. Ашигт малтмал хайх, ашиглахад бизнесийн авхаалж овсгоо туйлаас чухал. НТТ-ын бэрхшээлтэй асуудлууд үүгээр дуусахгүй. Энэхүү зарчмыг бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд дараах хүндрэл гардаг нь ажиглагджээ. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг мөрдүүлэхийн тулд уул уурхайн төслүүдийг эдийн засгийн бусад үйл ажиллагаанаас салган тусгайд нь зохицуулах шаардлагатай болдог. Ингэсэн нөхцөлд ордыг нээхэд гаргасан хайгуулын зардлыг лиценз эзэмшигчийн татвар ногдуулах орлогоос хасах боломж хязгаарлагддаг талтай. Энэ нь бизнесийн сэдэл, санаачлагыг боймлох аюултай.
- Мөн энэ НТТ-ыг ногдуулах нь хайгуулын ажлын хүрээг хумьдаг. Учир нь татварын тусгай зохицуулалтад хамрагдах хайгуулын ажлын

зардлаа татвар ногдуулах орлогоос хасч тооцуулах компаниудын сонирхлыг өөгшүүлж, зохицуулалтанд хамрагдахгүй буюу орд нээхээс өмнөх хайгуулын ажилд хөрөнгө зарцуулах сонирхлыг бууруулдаг.

- НТТ нь тухайн улсад хөрөнгө оруулалт хийх эрсдлийг нэмэгдүүлдэг. Хөрөнгө оруулагчдын бизнесийн идэвх санаачлагыг дэмждэг байхын тулд татварын дүрэм журам нь уул уурхайн төсөл хэрэгжих бүхий л хугацаанд тогтвортой, өөрчлөгддөггүй байх ёстой. Энэ нь улс төрийн болон төсөв санхүүгийн нөхцөл байдал нь эрс өөрчлөгдөх магадлал бүхий хөгжиж буй болон шилжилтийн үедээ байгаа улс орнуудын хувьд амаргүй. 1970-аад онд Папуа Шинэ Гвинейд анх удаа НТТ-ыг Рио Тинтогийн Бугэйнвилл уурхайд нэвтрүүлснийг жишээ болгон авч үзье. Гэнэтийн ашгаар улсын төсөвт их мөнгө авсан нь арлын энэ оронд нийгмийн эсэргүүцэл, тогтворгүй байдлыг өдөөж, улмаар 1989 онд уурхайг хаахад хүргэжээ. 2003 оны эхээр энэ татварыг бүрмөсөн цуцлах хүртэл төрөөс татварын тогтолцоондоо удаа дараалан өөрчлөлт хийсээр байжээ. Гэвч удахгүй хэрэгжих “LNG” төсөлд НТТ-ыг сэргээн нэвтрүүлэх тухай 2008 оны дундуур зарлажээ. Энэ нэн зөрчилтэй татварын улмаас тус оронд татварын тогтолцоо нь байнга савалж, хөрөнгө оруулалтын эрсдлийн талаар хөрөнгө оруулагчид улам бүр санаа зовох болж байна.
- НТТ нь уул уурхайн төслийн хэрэгжилт болон менежментийн үр ашиггүй байдлыг өөгшүүлдэг. Тухайлбал капиталын хэт үрэлгэн зарцуулалтыг үл тооход хүргэнэ. Учир нь капиталын зардлыг татвар ногдуулах орлогоос бүрэн хасч тооцдог бөгөөд НТТ нь ахиу ашиг олох сонирхлыг үгүй хийж ашигт ажиллагааны тодорхой түвшинг л баталгаажуулснаар хөрөнгө оруулагчийн арвич хямгач, аж ахуйч байх сонирхлыг мохоодог.
- Угаасаа мөрдөхөд маш түвэгтэй татварын концепт тул НТТ-ыг ногдуулах орлогыг тооцох, төлөхөд талуудад учрах хэлцлийн өртөг буюу техник ажиллагааны зардал харьцангуй өндөр байдаг. Техник ажиллагааны зардалд татвар төлөгчийн зүгээс хууль дүрмийг мөрдөхтэй холбоотой гаргаж буй зардал болон татварын байгууллагын үйл ажиллагааны зардал багтана.
- НТТ нь эрдэм шинжилгээ, судалгаанд (R&D) хөрөнгө зарцуулах, жижиг ордуудыг ашиглах сонирхлыг бууруулдаг. Учир нь эдгээр ажил нь өндөр эрсдэлтэй тул дээрх татварыг ногдуулах нь олж болох ашгийн түвшинд ноцтой нөлөөлдөг.

Үлдэж буй цорын ганц сонголт

Уул уурхайн салбарын татварын тогтолцоог боловсруулахад анхаарах гол асуудал нь татварын хувь хэмжээ, татварын бааз суурийн хоорондын хамгийн оновчтой тэнцвэрийг олоход оршино. Татварын хувь хэмжээ, татварын суурь баазын аль аль нь чухал ач холбогдолтой. Тэдгээрийн арифметик үржвэр нь цуглуулж хураасан татварын орлогын дүнг тодорхойлох боловч татварын түвшин нь татварын суурь баазын цар хэмжээнд маш том нөлөө үзүүлдэг.

Аль ч татвар нь татвар төлөгчдөд татвар төлөхөөс зайлсхийх, зугтах санаархлыг бий болгодог. Татварын хувь хэмжээ өндөр байх тусам татварын суурь хумигдаж, татвараас зайлсхийх санаархал даамжирна. Мэдээж ийм нөхцөлд татварын орлого үнэмлэхүй дүнгээрээ тун бага байх болно. Цаашилбал, татварын суурь бааз огт үгүй болж ямар ч орлого хуримтлагдахгүй байх аюултай.

Уул уурхайгаас бусад салбарт ч дээрхийн адил нөхцөл байдал үүсдэгийн олон жишээг харж болно.

тутам бодит дүнгээрээ 0.1% өссөн байв. Үүнээс үзвэл 1925 онд татварын хувь хэмжээг бууруулсан нь эдийн засагт эергээр нөлөөлж, үйлдвэрлэлийн түвшин хоёр дахин нэмэгдэж, ажилгүйдэл эрс буурчээ.¹²

Хөрөнгийн орлогод ногдуулах татварт өөрчлөлт хийх үед тухайн татвар нь татвар төлөгчийн зан аягт хэрхэн нөлөөлж буйг судлах боломж гардаг.

Хөрөнгийн орлогод ногдуулах татвар нь татвар төлөгчийн хувьд хөрөнгө оруулалтын өгөөж хүртэх цаг хугацаа, түүнчлэн татварын төлбөрийг хянах боломж олгодгоороо бусад төрлийн татвараас ялгаатай. Түүхэн туршлагаас харвал энэхүү хандлага тууштай ажиглагдсан: хөрөнгийн орлогын татварын хувь хэмжээг буурууламгц төсвийн орлого эрс нэмэгддэг, гэхдээ тийнхүү өссөнийхөө дараа буурдаг байна.

- 1981 онд АНУ-д хөрөнгийн орлогод ногдуулах татварыг 28% байсныг 20% болгож бууруулжээ. Уг татвараас төсөвт орох орлого 1980 онд 12.5 тэрбум доллар байсан бол 1983 онд 18.7 тэрбум доллар болж 50 хувиар өсчээ.

Уул уурхайн салбарын хувьд харьцангуй цөөн уурхайд харьцангуй өндөр татвар ногдуулахаас харьцангуй олон уурхайд харьцангуй бага хэмжээний татвар ногдуулах нь төсөвт илүү орлого оруулдаг.

Эдгээр жишээ нь татварын хувь хэмжээ болон татварын бааз суурь харилцан уялдаатайг нотолж байдаг. Уул уурхайн салбарын хувьд харьцангуй цөөн уурхайд харьцангуй өндөр татвар ногдуулахаас харьцангуй олон уурхайд харьцангуй бага хэмжээний татвар ногдуулах нь төсөвт илүү орлого оруулдаг.

АНУ-д холбооны орлогын татварыг 1913 онд нэвтрүүлэх үед татварын хувь хэмжээний дээд хязгаарыг ердөө 7% гэж тогтоосон боловч Дэлхийн нэгдүгээр дайны улмаас 1918 он гэхэд уг түвшинг 77% хүргэж өсгөжээ. 1925 онд АНУ орлогын татварын хувь хэмжээг бууруулж, дээд хязгаарыг нь 25% болгож багасгасан. Үүнээс өмнөх дөрвөн жилийн турш Холбооны Засгийн газрын орлого бодит дүнгээр жил тутам 9.2%-иар буурсан байжээ. Харин дараагийн дөрвөн жилд Холбооны Засгийн газрын орлого жил

- 1986 онд хөрөнгийн орлогын татварын хувь хэмжээг 20%-иас 28% хүртэл нэмэгдүүлсэн. Татвар нэмэгдүүлэхээс өмнө орлого эрс өсч, тухайлбал 1986 онд 328 тэрбум долларт хүрч байжээ. Гэвч татварын хувь хэмжээг нэмснээр орлого эрс унаж, 1991 онд 112 тэрбум доллар болж буурсан.¹³


Монгол улсын уул уурхайн салбарын татварын тогтолцоо эдүгээ яг ийм эгзэгтэй үедээ ирээд байна. Уул уурхайн шинэ төслүүдэд оногдох татварын бодит хувь хэмжээ нь төслүүдийг эдийн засгийн хувьд ашиггүй болгож буй нь улс орны эрх ашигтай зөрчилдөж байгааг Зураг 5-аас харж болно. ЗБҮӨАТ-ыг нэвтрүүлснээс хойш алтыг хууль бусаар хил давуулж наймаалах явдал эрс нэмэгдэж, албан ёсны мэдээгээр алтны үйлдвэрлэл үлэмж буурчээ. Шинэчлэл хийхгүй нөхцөлд гадаадын хөрөнгө

¹² Arthur B Laffer, 2004, *The Laffer Curve: Past, Present, and Future*, Heritage Foundation, 1 June, accessed at <http://www.heritage.org/Research/Taxes/bg1765.cfm> on 5 December 2008 /Артур Лаффер “Лафферийн муруй: өнгөрсөн, одоо, ирээдүй”/

¹³ Laffer 2004 /Лаффер, 2004/

Зураг 5

Монгол, Чили улс дахь алт-зэсийн томоохон компанид ногдуулах татварын бодит хувь хэмжээ /1997-2007 оны алт, зэсийн үнэд үндэслэн 2008 оны үнэд хөрвүүлснээр



Эх сурвалж: Дэлхийн Өсөлт байгууллагын тооцоо

оруулагчид Монгол улсын ашигт малтмалын хайгуул, олборлолтын салбарт хөрөнгө оруулалт хийхээс зайлсхийж болзошгүй.

Томоохон шинэчлэлийн үндсэн чиг баримжаа нэгэнт тодорхой байна. Уул уурхайн төслүүдэд ногдуулах татварын бодит хувь хэмжээг нийтэд нь дорвитой бууруулах шаардлагатай. Ингэсэн тохиолдолд татварын өнөөгийн тогтолцооны улмаас бий болж

Уул уурхайн төслүүдэд ногдуулах татварын бодит хувь хэмжээг нийтэд нь дорвитой бууруулах шаардлагатай. Ингэсэн тохиолдолд татварын өнөөгийн тогтолцооны улмаас бий болж болзошгүй зогсонги байдлаас зайлсхийж, уул уурхайн салбар нь өргөжин илүү хурдацтай хөгжих боломж бүрдэнэ.


болзошгүй зогсонги байдлаас зайлсхийж, уул уурхайн салбар нь өргөжин илүү хурдацтай хөгжих боломж бүрдэнэ. Ингэж чадваас дотоодын хөдөлмөр эрхлэлт, ДНБ болон татварын орлогыг урт хугацаанд тогтвортой нэмэгдүүлж улмаар ард иргэдийн аж амьдралд бодитой хувь нэмэр оруулж чадахуйц уул уурхайн салбарыг хөгжүүлэх нөхцөл бий болно. Учир нь, татварын өнөөгийн тогтолцоо нь урт удаан хугацаанд тогтвортой орлого бүрдүүлэх чадваргүй нь харагдаж байна.

Ашигт малтмалын нөөцөө урт удаан хугацаанд үр өгөөжтэй ашиглахын тулд уул уурхайн салбарын татварыг оновчтой түвшинд тогтоохын ач холбогдлыг Чилийн туршлага тодорхой харуулж байна. Чилийн татварын бодит хувь хэмжээ нь дэлхийн бусад улс орныхтой харьцуулахад тууштай хамгийн бага түвшинд байсаар ирсэн.¹⁴ Үүний хамгийн тод илрэл нь өнгөрсөн хорин жилд ашиглалтанд оруулсан зэсийн уурхайнуудын хамгийн өндөр бүтээмж, хүчин чадалтай үйлдвэрүүдийн ихэнх нь Чилид байдаг явдал юм. 1980-аад оноос Чили улсад эхэлсэн уул уурхайн хөрөнгө оруулалтын үсрэнгүй дэвшлийн цар хүрээг Зураг 6-д тодорхой харуулав.

14 Otto et al 2000 /Отто ба бусад 2000/

Зураг 6

Чили улсын уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт,
1980-2007, сая ам доллараар



Эх сурвалж: Chile Comite de Inversiones Exteranjeras as cited in G Moguillansky, *Chile: Las Inversiones en el sector minero 1980 - 2000*, НҮБ Латин Америк, Карибын Эдийн засгийн хороо, Эдийн засгийн цуврал шинэчлэл 3

Татварын оновчтой зохицуулалт дангаараа хангалтгүй бөгөөд бодлогын ерөнхий орчин тогтвортой, цаашдын төлөв нь урдаас тодорхой байх явдал зайлшгүй чухал. Чили улсын жишээ нь зохицуулалтын орчинг оновчтой бүрдүүлсний үр өгөөжийг харуулахын хажуугаар энэхүү орчинд өөрчлөлт хийх нь олон улсын түвшинд өрсөлдөх чадварын асуудлаар асар их хүчин чармайлтын үрээр олж авсан байр сууриа хэрхэн амархан алдаж болохыг мөн харуулдаг. Дэлгэрэнгүйг Хавсралт А-д тусгав.

Тодорхой уул уурхайн төслүүдэд үзүүлэх татварын хөнгөлөлтөө Хөрөнгө оруулалтын гэрээнд тохиролцон тусгах замаар татварын томоохон шинэчлэл хийхээс зайлсхийж болно хэмээх бодол Монголын зарим хүмүүст байдаг бололтой.

Энэ бол туйлын алдаатай бодол санаа юм. Энэ байдлаар урт хугацааны ирээдүйд хамаарах асуудалд хандахад засгийн газарт мэдээлэл ч, захиргааны мэдлэг туршлага ч дутагдана. Захиргааны чадамж бий болсон ч мэдээллийн хомсдолоос зайлсхийж чадахгүй.

Түүгээр зогсохгүй, уул уурхайн салбарт үйлчлэх тодорхой, тууштай, тогтвортой татварын бодлогын зарчмууд үгүйлэгдэж буй нь Монголд хөрөнгө

оруулах эрсдэл улам бүр нэмэгдэнэ гэсэн ойлголтыг гадаадын хөрөнгө оруулагчдад өгч байна. Энэ нь юуны түрүүнд хайгуулын хөрөнгө оруулалт буурахад хүргэж, улмаар хайгуулын ажлын идэвх сулрах нь ирээдүйд олон шинэ уурхай бий болж, урт хугацаандаа тус салбар тогтвортой өргөжин хөгжих боломжийг үгүй хийж байна.

Оюу Толгойн ордод тулгуурлан хайлуулах үйлдвэр байгуулж ажиллуулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр болвол ЗБҮӨАТ-аас лиценз эзэмшигчийг чөлөөлж татварын хэт ачааллыг үгүй

Энэ нь юуны түрүүнд хайгуулын хөрөнгө оруулалт буурахад хүргэж, улмаар хайгуулын ажлын идэвх сулрах нь ирээдүйд олон шинэ уурхай бий болж, урт хугацаандаа тус салбар тогтвортой өргөжин хөгжих боломжийг үгүй хийж байна.

хийж болно гэж үздэг хүмүүс ч байна.

Энэ санаа ч мөн алдаатай юм. Хэрэв Монголд эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах нь эдийн засгийн хувьд ашигтай байсан бол уул уурхайн компаниуд татварын хөнгөлөлт хүсэлгүйгээр аль хэдийнэ хөрөнгө оруулалт хийх байсан. Харин Монголд эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ашиггүй байх бол, дээр дурьдсан хөнгөлөлт чөлөөлөлтийн талаарх тохиролцоо нь олборлох салбарт орж ирэх хөрөнгө оруулалтыг үгүй хийж эцсийн дүндээ Монгол улсад туйлын хохиролтой байдал үүснэ.

Уул уурхайн салбарт ногдуулах татварын бодит хувь хэмжээг бууруулах нь Монгол улсад амин чухал боловч татварын ачааллын бүтэц нь үүнээс дутуугүй ач холбогдолтой. Энэ чиглэлээр Дэлхийн Банкнаас Монголын засгийн газарт хандаж уул уурхайн татварын зохицуулалтыг олон улсын шилдэг жишигт ойртуулах үүднээс авч хэрэгжүүлэх шинэчлэлийн багцын зарим асуудлуудаар зөвлөмжөө танилцуулж байжээ. Монгол улсын Засгийн газарт өгсөн Дэлхийн Банкны санал зөвлөмжийн тоймыг Хавсралт В-д үзүүлэв.

Шинэчлэлийн үндсэн чиглэлүүдийг дор сийрүүлэв. Үүнд:

- Гэнэтийн ашгийн татварыг халах (бөгөөд/эсвэл НТТ-аар орлуулах),

- “Стратегийн” ач холбогдолтой ашигт малтмалын ордуудад төрийн оролцоо байх заалтыг хасах,
- Алт, зэсэнд ногдуулах нөөц ашигласны татварын хэмжээг Хайлуулах үйлдвэрийн борлуулалтын цэвэр орлогын 4%-иас хэтрэхгүй байхаар бууруулах,
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээг 30%-иас хэтрүүлэхгүй, болж өгвөл 25% орчим байхаар тогтоох,
- Татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн орлогын татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлж тооцох хугацаанд хязгаарлалт тавихгүй байх.

Ашигт малтмалын хайгуул, ашиглалтанд хөрөнгө оруулалт хийхэд таатай орон гэсэн урьдын нэр хүндээ сэргээж, гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө, мэргэжлийн мэдлэг ур чадвар Монгол улсын эдийн засгийн хөгжилд чухал гэдгийг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлэхийн тулд Монгол улс эдгээр өөрчлөлтийг нэн даруй хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ хандлагаараа дараа дараагийн бодлогын өөрчлөлтийг аажмаар, алхам алхмаар хэрэгжүүлж болно.

Хавсралт А: Папуа Шинэ Гвиней улсын татварын орчин ба уул уурхайн хөгжил

Фрэйзерийн Хүрээлэнгийн 2007-2008 оны судалгаанд ашигт малтмалын салбарын потенциалыг нь үнэлэхэд Папуа Шинэ Гвиней (ПШГ) улс дэлхийд тун дээгүүр жагсчээ.¹⁵ Гэтэл үүнээс эрс ялгаатай нь хөрөнгө оруулалт татах чадвараараа уг хүрээлэнгийн хэмжүүрээр ПШГ 68 орноос 55 дугаарт оржээ. Ингэж доогуур байранд орж буй нь тус улсын уул уурхайн татвар, зохицуулалтын орчны түүхэн хөгжлийн явцтай ямар нэг байдлаар холбоотой.

ПШГ-н Засгийн газар 1996-2000 оны хооронд нөөц ашигласны татварыг /роялти/ 1.25%-иас 2% болгож өсгөсөн ба олборлолтын тооцож болох орлогод 4%-ийн татвар нэвтрүүлсэн нь үнэн хэрэгтээ нэмэлт роялти болсон байна.

ПШГ улсад аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас гадна зарим төслийн хувьд Нэмэгдсэн ашгийн албан татварыг (НААТ) ногдуулж хайгуулын зардлыг татвараас хасч тооцоход хязгаарлалт тавьсан. НААТ нь НТТ-ын нэг хэлбэр бөгөөд үүнийг дотоод өгөөжийн босго хувь хэмжээнээс хэтэрсэн ашигт ногдуулдаг.

Дээр дурдсан хугацаанд ПШГ-н төр засгаас ашигт малтмалын ордыг эзэмших гэрээ байгуулахад хувь эзэмшлийн 30 хүртэл хувийг төр эзэмших эрхийг хуульчилсан. Төрийн өмчийн оролцооны төлбөрийг Засгийн газар хийхдээ төслийн зах зээлийн нийт өртгийг бус хайгуулын зардлын өртгийг үндэс болгожээ.

Металлын үнэ буурсан, хөрөнгө оруулалтын асуудалд засгийн газрын зүгээс учруулж болох эрдлийн талаарх болгоомжлол газар авсан, дотоодын улс төрийн байдал хүндэрсэн цаг үед эдгээр бодлогын өөрчлөлтийг ПШГ-н Засгийн газар нэвтрүүлж байлаа.

2000 он гэхэд ПШГ нь олон улсын түвшний уул уурхайн хөрөнгө оруулалтыг татах тал дээр өрсөлдөх чадваргүй нь илэрхий болсон. Хэдийгээр 1996-2000 оны хооронд металлын үнэ унасны улмаас дэлхий даяар ашигт малтмалын хайгуул багассан ч Папуа Шинэ Гвинейд хайгуулын ажил бүр илүү хурдацтай хумигдаж байв. Улмаар дэлхий дахины хайгуулын хөрөнгө оруулалтаас тус улсад ногдох хувь хэмжээ эрс багассан.

ПШГ-н Засгийн газраас эрдэс баялгийн болон газрын тосны салбарын татварын бодлогоо дахин нягталж үзэхэд хүрсэн. Ингэснээр бодлогын хэд хэдэн өөрчлөлт хийх санал гарган. 2000 онд Засгийн газар бүх шинэ төслүүдэд ногдуулах олборлолтын татварыг тэглэж¹⁶, мөн дээрх өөрчлөлтийг одоо хэрэгжиж буй төслүүдэд үе шаттайгаар нэвтрүүлнэ гэж мэдэгдсэн. НААТ-ын хувь хэмжээг бууруулахын зэрэгцээ НААТ ногдуулах дотоод өгөөжийн босгыг намсгасан нь НААТ-ын хувь хэмжээг 20%-иас 15%-д хүргэж бууруулсан.

2002 онд ПШГ-н Засгийн газар уул уурхайн

татварын хууль тогтоомжоо дахин хянаж үзсэн.

Улмаар 2003 оны эхээр НААТ-ыг бүрмөсөн

халснаас гадна аж ахуйн нэгжийн орлогын

албан татварыг 30%, ногдол ашгийн суутгалын

татварыг 10% болгож бууруулсан. Ашигт

малтмалын нөөц ашигласны татварыг

Хайлуулах үйлдвэрийн борлуулалтын цэвэр

орлогын 2%-тай тэнцүү тогтоосон бөгөөд

хээрийн бус хайгуулын зардлыг аж ахуйн

нэгжийн орлогын албан татвараас хасч тооцоход

мөрдөж байсан хязгаарлалтыг зөөлрүүлсэн.

Уул уурхайн салбарынхан болон олон улсын хөрөнгө оруулагчдын зүгээс олборлолтын татварыг халсан явдлыг нааштай хүлээн авсан ч НААТ-ын босгыг намсгасныг таашаагаагүй. Учир нь нэвтрүүлсэн цагаас авахуулаад НААТ нь уул уурхайн хөрөнгө оруулалтад сөрөг үр дагавар учруулж байсан нь байнгын санаа зовоосон асуудал болж байв. Олборлолтын татварыг тэглэсэн хэдий ч ПШГ нь олон улсын түвшинд уул уурхайн хөрөнгө оруулалтыг татах талаар өрсөлдөх чадваргүй хэвээр үлдэж, дэлхийн ашигт малтмалын хайгуулын хөрөнгө оруулалтаас тус улсад ногдох хувь хэмжээ нэмэгдээгүй.

¹⁵ Фрэйзерийн Хүрээлэнгийн судалгаа, 2008

¹⁶ Татварыг үе шаттайгаар тэглэх үйл ажиллагааг 2007 оны эцэс гэхэд дуусгахад төлөвлөсөн. (ОУВС 2008)

2002 онд ПШГ-н Засгийн газар уул уурхайн татварын хууль тогтоомжоо дахин хянаж үзсэн. Улмаар 2003 оны эхээр НААТ-ыг бүрмөсөн халснаас гадна аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 30%, ногдол ашгийн суутгалын татварыг 10% болгож бууруулсан. Ашигт малтмалын нөөц ашигласны татварыг Хайлуулах үйлдвэрийн борлуулалтын цэвэр орлогын 2%-тай тэнцүү тогтоосон бөгөөд хээрийн бус хайгуулын зардлыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасч тооцоход мөрдөж байсан хязгаарлалтыг зөөлрүүлсэн. Эцэст нь уул уурхайн аливаа шинэ төсөлд 30 хүртэлх хувийн төрийн оролцооны хувийг тогтоосон хуулийн заалтаа эргэн харах арга хэмжээг Засгийн газраас авсан.

Эдгээр бодлогын өөрчлөлтүүд эерэг үр дүнг авчирсныг бодит байдлаас харж болно. Дэлхийн хайгуулын хөрөнгө оруулалтаас тус улсад ногдох хувь хэмжээ эргэн нэмэгдсэн. Сүүлийн үеийн судалгаагаар бусад орны уул уурхайн хууль тогтоомжтой харьцуулахад ПШГ-н дэх уул уурхайн хөрөнгө оруулалтын үр өгөөж нэмэгдсэн¹⁷. Зэсийн уурхайн өгөөжийн дотоод хувь хэмжээг авч үзэхэд,

ПШГ нь 24 улсаас 1999 онд 20 дугаарт жагссан бол 2003 онд 4 дүгээрт эрэмбэлэгджээ.

2002 оноос хойш хийгдсэн шинэчлэлээс үл хамааран бодлогын олон хүчин зүйл ПШГ-н уул уурхайн хөрөнгө оруулалтын орчинд бодитой сөрөг нөлөө үзүүлсэн хэвээр байгааг Фрэйзерийн Хүрээлэнгийн судалгаанд дурдсан байна. Тухайлбал тус хүрээлэнгийн “сайжруулах боломжийг үнэлсэн индекс”-ийн хэмжүүрээр Папуа Шинэ Гвиней 2007-2008 оны байдлаар 68 орноос 16 дугаарт бичигджээ. Сөрөг үр дагавруудад зан заншлаас үүдэлтэй газар эзэмшлийн маш тодорхойгүй систем, аюулгүй байдлын доогуур түвшин, газар авсан авилга зэрэг хамаарна.

Төслийн хөрөнгө оруулагчидтай тохиролцсоны дагуу ExxonMobil-ийн тэргүүлэн хэрэгжүүлэх “PNG LNG” төсөлд НААТ-ыг дахин нэвтрүүлнэ гэдгийг ПШГ-н Засгийн газар 2008 оны 5 сарын эцсээр мэдэгдсэн. “LNG” төслийн хамтарсан үйлдвэрийн бүтээгдэхүүнийг 2013 оны эцэс буюу 2014 оны эхээр экспортлохоор төлөвлөөд байна.

¹⁷ James Otto, 2002, ‘Materials for a Workshop on the Provision of the Papua New Guinea Tax System as Compared to Mining Taxation Systems of other Nations’, *Report Prepared for the PNG Department of Mining and The World Bank*, as quoted in Otto et al 2006. /Жэймс Отто, ПШГ-н татварын тогтолцоог бусад орныхтой харьцуулах нь сэдэвт семинарын материалаас/

Хавсралт Б: Чили улсын татварын орчин ба уул уурхайн хөгжил

1970-аад оны эцэс 1980-аад оны эхээр Чилийн Засгийн газар хувийн хөрөнгө оруулалтыг татахын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг либеральчилсан. Үүний үр дүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт нь Чилийн зэсийн үйлдвэрлэл болон тус улсад шинээр томоохон хэд хэдэн уурхайг байгуулж ашиглах хувийн компаниудын хөгжилд их үүрэг гүйцэтгэсэн. Зэсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдан өссөн бөгөөд Чили улсын эдийн засгийн өсөлт эрс хурдассан нь чухамхүү зэсийн үйлдвэрлэл эрс өргөжсөнгтэй голчлон холбоотой.

Хорь гаруй жилийн туршид Чили улс уул уурхайн хувийн хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын маш таатай орчин бүрдүүлж өгсөн. Фрэйзерийн

Хүрээлэнгийн судалгаагаар хөрөнгө оруулалт татах чадавхийн үнэлгээгээр Чили улс ямагт эхний хэдэн байрт орж байсан ба 2007-2008 оны байдлаар 6 дугаарт бичигджээ. Ийнхүү таатай орчин бүрдүүлсэн явдал нь Чилийн ашигт малтмалын татварын тогтолцоо, ялангуяа аж ахуйн нэгжийн татварын ерөнхий зохицуулалтаас үүдэлтэй.

Чили улсын уул уурхайн салбарын татварын орчин

Чили улсад аж ахуйн нэгжийн орлогын албан татварын суурь хувь хэмжээ 17 байдаг. “Codelco” компани энэхүү суурь хувь хэмжээн дээр нэмж 40% татвар төлдөг бөгөөд жилийн экспортын орлогын 10%-тай тэнцэх мөнгийг зэвсэгт хүчинд шилжүүлэх үүрэгтэй. Гадаадын өмчлөлтэй компаниуд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын доорх хоёр

Чили улсын зэсийн уурхайнуудын өмчлөл ба бүтээгдэхүүний гарц, 2003 оны байдлаар


Хүснэгт

Үйлдвэрлэлийн анхны жил	Компанийн нэр	2003 оны бүтээгдэхүүний гарц(а)	Өмчлөл
Codelco			
1980 оноос өмнө	Chuquicamata	601	Чилийн Засгийн газар
1980 оноос өмнө	El Teniente	339	Чилийн Засгийн газар
1980 оноос өмнө	Andina	236	Чилийн Засгийн газар
1980 оноос өмнө	Salvador	80	Чилийн Засгийн газар
1998	Radomiro Tomic	306	Чилийн Засгийн газар
	<i>Нийт</i>	<i>1 563</i>	
Бусад үйлдвэрлэгчид			
1980 оноос өмнө	Disputada	278	Anglo American
1980 оноос өмнө	Mantos Blancos	147	Anglo American
1980 оноос өмнө	Enami	122	Чилийн Засгийн газар
1990	Escondida	995	BHP Billiton, Rio Tinto plc, Mitsubishi, IFC
1994	Candelaria	213	Phelps Dodge
1994	Cerro Colorado	132	BHP Billiton Gr
1994	Quebrada Blanca	80	Aur Resources Inc.
1994	Michilla	53	Antofagasta
1995	Zaldivar	151	Placer Dome
1996	El Abra	227	Phelps Dodge, Codelco
1998	Collahuasi	395	Anglo American, Noranda, Mitsui, Nippon Mg Hold
1998	Lombas Bayas	60	Noranda
1999	Los Pelambre	338	Antofagasta
2001	El Tesoro	92	Antofagasta, Equatorial
	Others	61	
	<i>Нийт</i>	<i>3 342</i>	
	Бүгд	4 905	

Жич: (а) бүтээгдэхүүний гарцыг мянган тонн зэсийн баяжмалаар /contained copper/ тооцов. Эх сурвалж: Чили улсын Засгийн газар, Чилийн Зэсийн Хороо, 2006 он

Зураг 6

Чили улсын уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт,
1980-2007, сая ам.доллараар



Эх сурвалж: Chile Comite de Inversiones Exteranjeras as cited in G Moguillansky, *Chile: Las Inversiones en el sector minero 1980 - 2000*, НҮБ-ийн Латин Америк, Карибын Эдийн засгийн хороо, Эдийн засгийн шинэчлэлийн цуврал 3

хувилбараас аль нэгийг сонгож татвараа төлөх боломжтой.

- **I** Хувилбараар гадаадад шилжүүлэх орлогоос татвар авахдаа татвар ногдуулах орлогын нийт дүнгээс аж ахуйн нэгжийн татвар төлснийг харгалзан 15%-иар хорогдуулан тооцож 35%-ийн татвар ногдуулна.
- **II** Хувилбараар татварын хувь хэмжээг 10 жил өөрчлөхгүйн хариуд ногдол ашиг, хуваарилалт, гадаад шилжүүлгээс 42%-ийн татвар төлөх бөгөөд 50 сая ам.доллараас дээш хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд татварыг 20 хүртэл жил өөрчлөхгүй.

17%-ийн жишиг татварын суурь татварыг дээрх хоёр хувилбарын аль алинд компанийн нэмэлт татвар ногдуулах орлогыг тодорхойлоход хасч тооцно.

“Escondido” зэрэг гадаадын зургаан хөрөнгө оруулагч II Хувилбарыг сонгож, бусад бүх компани I Хувилбарыг сонгосон байна.

Өр ба өөрийн хөрөнгийн харьцааг боломжит дээд түвшинд хүргэх зорилгоор алдагдлыг ирээдүйд шилжүүлж тооцоход цаг хугацааны хязгаарлалт тогтоогоогүй. Элэгдэл хорогдлыг түргэвчилсэн

нормоор тооцох бөгөөд шимтгэл хийх хугацааг 7 жилээр тогтоож болно. Техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа, ашиглалтын өмнөх үйл ажиллагаа, хайгуул болон уурхайг ашиглалтад оруулахтай холбоотой зардлуудыг хөрөнгө оруулалтад хамааруулж татвараас чөлөөлж болно.

Хоёр улсын хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын хэлэлцээрээр гадаадын банкнаас авсан зээлийн хүүгийн төлбөрт ногдуулах суутгалын татварыг 35%-иас 4% хүртэл бууруулах боломжтой.

Чили улс 2006 оны 1 сарын 1-нээс эхлэн ашигт малтмалын нөөц ашигласны роялти татварыг татвар ногдуулах орлогын 0.5- 5%-ийн хооронд тогтоохоор болсон. Үүнд ирээдүйд төлөх татварын урьдчилсан төлбөр багтах бөгөөд үүнийг шинэлэг төслүүд, бүс нутгийн хөгжлийг санхүүжүүлэх зорилгоор нэвтрүүлсэн. 2008 он хүртэл нөөц ашигласны татварын 50 хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасч тооцож байсан.

Чили улсын хөгжилд уул уурхайн салбарын оруулсан хувь нэмэр

Эдүгээ дэлхийн тэргүүлэх 24 металлын компанийн зургаа нь Чили улсад байгаа бөгөөд дэлхийн зэсийн үйлдвэрлэлийн гуравны нэгийг нийлүүлж байна. 2005

онд зэсийн үйлдвэрлэл дангаараа Чили улсын ДНБ-ий 13%, мөн экспортын орлогын 50% хувийг бүрдүүлсэн.

Чили улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын хэмжээ дорвитой өсч, Чили улсын 2006 оны үндсэн хөрөнгийн нийт зардлын гуравны нэгтэй тэнцсэн. ГШХО-ын ихэнх хэсгийг хуримтлуулсан орлогоос санхүүжүүлж, гол төлөв уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийсэн. Доорх зургийг үзнэ үү. Эдүгээ дэлхийн ашигт малтмалын хайгуулын зардлын 3% нь Чили улсад ногдож байгаа ба шинэ ордуудыг нээж ашиглах өртөг зардал улам бүр нэмэгдсээр байна.

Уул уурхайн салбарт 90,000 хүн ажиллаж байгаа нь хөдөлмөр эрхлэж буй хүн амын 1%-ийг эзэлдэг. 1994-2004 оны хооронд хөдөлмөрийн хөлсний бодит хэмжээ жил тутам 2.4% өссөнөөс гадна 1990 оноос хойш ядуучуудын тоо тэн хагасаар буурах боломжтой болсон.

Фрэйзерийн хүрээлэнгийн судалгаагаар Чили дэлхийд өрсөлдөх чадвараар 2005-2006 онд 3 дугаар

байранд байсан бол 2006-2007 онд 27 дугаар байр руу ухарсан. Ухралтын гол шалтгаан улс төрийн тогтвортой, найдвартай байдал суларсантай холбоотой. Энэ нь уул уурхайн гол томоохон компаниуд тухайн улсын бодлого тогтвортой, байдал тодорхой байхыг чухалчилдгийг харуулахын сацуу нөөц ашигласны татварын шинэ хувь хэмжээ нэвтрүүлсэнтэй цаг хугацааны хувьд давхцсан.

Монгол улсад сургамжтай үр нөлөө

Уул уурхайн үйлдвэрлэлийн татварын оновчтой зохицуулалт нь ашигт малтмалын олборлолтоос урт хугацааны туршид бий болох үр өгөөжийг аль болох дээд хэмжээнд хүргэхэд чиглэдгийг Чилийн туршлага харуулж байна. Гэвч энэ нь хангалттай бус. Бодлогын ерөнхий орчин хүрээ нь тогтвортой, цаашдын төлөв нь урдаас тодорхой байх явдал зайлшгүй чухал. Чили улсын жишээ нь зохицуулалтын орчинг оновчтой бүрдүүлсний үр өгөөжийг харуулахын хажуугаар энэхүү орчинд өөрчлөлт хийх нь олон улсын түвшинд өрсөлдөх чадварын асуудлаар ихээхэн чармайн байж олж авсан байр сууриа хэрхэн амархан алдаж болохыг мөн харуулдаг.

Хавсралт В: Монгол улсын уул уурхайн татварын тогтолцоог олон улсын шилдэг жишигт ойртуулах талаар Дэлхийн Банкнаас өгсөн зөвлөмж

Саяхан Дэлхийн Банкнаас дэлхий дахинд ашигт малтмалын хайгуул, олборлолтод хэрэгжүүлдэг татварын орчныг үнэлсэн.¹ Олон улсын шилдэг жишигт ойртуулахтай холбоотой бодлогын чиглэл асуудлуудаар Монгол улсын Засгийн газарт санал болгож буй Дэлхийн Банкны зөвлөмжийг доорх хүснэгтэд тусгаж үзүүлэв.

Хүснэгт

Татварын заалтууд, дэлхийн шилдэг туршлага

Татварын заалтууд	Шилдэг туршлага
ААН-ийн орлогын албан татвар	25%-30%
Ногдол ашгийн суутгалын татвар	15%
Нөөц ашигласны татварын хувь хэмжээ (Роялти татвар, <i>ad valorem</i> зарчмаар)	2%-4%
Гэнэтийн ашгийн татвар	Байхгүй
Уул уурхайн үйлдвэр, тоног төхөөрөмжид ногдуулах импортын татвар	Байхгүй
Ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын татвар	Байхгүй
Нэмүү өртгийн татвар	Буцааж олгох
Уул уурхайн үйлдвэр, тоног төхөөрөмжийн элэгдэл	Түргэвчилсэн нормоор тооцож, нэгтгэсэн элэгдэл хорогдол
Хорогдлын төлбөр	Байхгүй
Уул уурхайн төслүүдийг эдийн засгийн бусад үйл ажиллагаанаас ангилан тусгай зохицуулалтаар татвар ногдуулах	Байхгүй
Хайгуулын зардлыг тооцох нь	5 жилд хорогдуулж тооцно
Байгаль орчны зардлыг тооцох нь	Зарцуулагдсан байх
Уурхайг хаах, нөхөн сэргээлтийн зардлыг тооцох нь	Эдгээр зардлыг татвар ногдуулах орлогоос хасч, тусгай санд төвлөрүүлнэ
Татварын хөнгөлөлт чөлөөлөлт	Байхгүй
Татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлж тооцох	Хязгааргүй буюу 7 жил хүртэл

Эх сурвалж: Дэлхийн Банк 2008



Дэлхийн Өсөлт Монголын Төсөл

Монгол дахь Дэлхийн өсөлт байгууллагын тухайд

Монгол дахь Дэлхийн өсөлт байгууллага нь Монгол Улсад тулгарч буй хүнд бэрхшээлийг шийдэх бодлогыг хөхүүлэн дэмжих зорилгоор байгуулагдсан ашгийн бус ба төрийн бус байгууллага юм. Монгол дахь Дэлхийн өсөлт байгууллага даяарчлалын шинэ эрин үе, ядуурлыг бууруулах, амьдрах орчныг сайжруулах, монголын ард түмэнд шинэ ажлын байр, боломж бий болгох чөлөөт худалдааны хүчин чадлыг хүлээн авч үнэлж байна. Бид өөрсдийн баримталдаг 5 үндсэн зарчмыг хөхүүлэн дэмжих хэрэгцээ шаардлагатай гэдэгт бат итгэдэг. Үүнд: Эдийн засгийн эрх чөлөө; Сайн засаглал; хуулийг дээдлэх ёс ба хуулийн тогтвортой байдал; Өмчтэй байх эрх; Байгаль орчны харилцан хамаарал. Дэлхийн өсөлт байгууллагын талаар нэмэлт мэдээллийг www.worldgrowth.mn эсвэл www.world-growth.org вебсайтаас авна уу.



WORLD GROWTH
MONGOLIA



Дэлхийн Өсөлт
Монголын Төсөл

Монгол улс
Улаанбаатар хот
Амарын гудамж
Сүхбаатар дүүрэг
Адмон компаний байр Гурав дугаар давхар

(976) - 11 - 330902

<http://www.worldgrowth.mn/?url=contact&lang=mn>